Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын
2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
А/32 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Архангай аймгийн Засаг даргын тамгын газар | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга | Ахлах түшмэл, ТЗ-10 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдрийн 8 цаг | Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг, Нутгийн захиргааны ордон |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн байгууллагыг бодлогын зөвлөмж, арга зүйгээр хангаж, чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.

**<u>Албан тушаалын зорилт:</u>**

1.Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгжийн нэгтгэсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлага, албан хаагчдыг бодлогын зөвлөмжөөр хангах, төрийн байгууллагуудад арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

2.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, мэдээлж тайлагнах, арга зүйн зөвлөмжөөр хангах,чадавхжуулах, гүйцэтгэл үр дүн, үр нөлөөг сайжруулах;

3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний бодит мэдээ, мэдээллээр удирдлага болон хэрэглэгчийг хангах;

4.Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл, хяналтыг хийж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах ажлыг зохион байгуулах. | Хугацаанд нь үнэн зөв тайлагнасан эсэх | Т, Х, Г |
| | 2. Монгол Улсын Засгийн газар, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах ажлыг зохион байгуулах | Хугацаанд нь үнэн зөв тайлагнасан эсэх | Т, Х, Г |
| | 3. Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах ажлыг зохион байгуулах | ХШҮ хийсэн хөтөлбөр, төслийн тоо, биелэлтийн хувь | Т, Х, Г |
| | 4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг тооцох, тайлагнах | ХШҮ хийсэн шийдвэрийн тоо, биелэлтийн хувь | Т, Х, Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Аймгийн Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагаанд явцын болон эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнах | Хугацаандаа тайлагнасан эсэх, үнэлгээний хувь | Х, Г |
| | 2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийт, төрийн бус байгууллагын | Агентлаг | Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | оролцоог ханган иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг үе шаттай хэрэгжүүлэх<br>3. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын Засаг дарга түүний Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагаанд явцын болон эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах<br>4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар удирдлага болон хэлтэс, агентлагийн ажилтнууд, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах | сумдын тоо, сэтгэл ханамжийн үнэлгээний хувь<br>Хугацаандаа тайлагнасан эсэх, үнэлгээний хувь<br>Санал зөвлөмж мэдээллийн тоо | Х, Т, Г<br>Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. "Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс"-ийн үйл ажиллагааны тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, аймгийн вэб сайтад тухай бүрд нь мэдээлэх ажлыг зохион байгуулах<br>2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийг аймгийн цахим хаяг, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ил тод болгох<br>3. Нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудсанд хяналт тавьж, зөвлөгөө зөвлөмж өгөх, гүйцэтгэлийг хангуулах | Мэдээлсэн мэдээллийн тоо<br>Нийтэд мэдээлсэн мэдээллийн тоо<br>Зөвлөмжийн тоо | Т Х,<br>Х, Т<br>Х, Т |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Хэлтсийн ажлыг жил, хагас жил, улирал, сараар төлөвлөж, хэрэгжилтийг хангах, тайлагнах<br>2. Хэлтсийн ажлыг бусад нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах<br>3. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтаа хугацаанд нь шилжүүлэх<br>4. Хэлтсийн албан хаагчдыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төлөвлөлтөд хяналт тавьж, гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, дүгнэх,<br>5. Ажилтнуудын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн эрх бүхий | Хугацаандаа хэрэгжсэн эсэх<br>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна | Г<br>Г<br>Г, Х<br>Г<br>Г |

МОНГОЛ УЛС ЗОВШООРОВ ... ӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | этгээдэд санал гаргана.<br>6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх | Хугацаандаа хэрэгжсэн эсэх | Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | |
| Мэргэжил | - эрх зүй /042/<br>- эрүүл мэнд /091/<br>- нийгмийн хамгаалал /092/<br>- хүмүүнлэг /022/<br>- бизнес ба удирдахуй /041/<br>- боловсрол /011/<br>- нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031/<br>- хөдөө аж ахуй /081/<br>- архитектор ба барилга, угсралт /073/<br>- инженерчлэл /078/ | |
| Мэргэшил | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдсан байх | |
| Туршлага | Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;<br><br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх; | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;<br>- хариуцсан нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах шаардлага тавьж чаддаг байх<br>- удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой тэнцвэртэй хуваарилах, удирдах<br>- үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;<br>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих,<br>- албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, хуульд нийцсэн заавар чиглэл өгөх<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- бусад |
| | Дүн шинжилгээ хийх | - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, харьцуулах, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах шийдвэрийн эерэг болон сөрөг үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх<br>- баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх<br>- судалгааны арга зүй эзэмшсэн байх<br>- бусад |
| | Асуудал шийдвэрлэх | - хууль тогтоомжид нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах;<br>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | |
|---|---|---|
| | | боловсруулах;<br>- албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх;<br>- бусад |
| | Манлайлах | - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх;<br>- шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;<br>- байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;<br>- аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх.<br>- бусад |
| | Бусад | - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;<br>- мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;<br>- багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох; |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект |
|---|---|
| Ахлах мэргэжилтэн .....<br>Мэргэжилтэн .....<br>Төрийн үйлчилгээний албан хаагч .....<br>Нийт ...... | - Сумын ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд,<br>- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албаны дарга, мэргэжилтнүүд,<br>- Иргэн, хуулийн этгээд, |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА<br>........................ /Ш.Гомбодорж/<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>20.... оны..... дугаар сарын .....-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 22.05.11<br>Дугаар: 335<br>МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ |

| VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН |
|---|
| Байгууллагын нэр:<br>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2022 06 23<br>Дугаар: 32<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА ................ /Ц.БАДРАХ/<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ